

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

**Ковид-19 халдвараас сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх чиглэлээр:** Аймгийн Гамшгийн сангаас 75929,0 мянган төгрөгийн санхүүжилтээр коронавирусийн халдварын шинжилгээ хийх оношлуур 3932 ширхэг, 2200 хос үзлэгийн бээлий, N-95 амны хаалт 200 ширхэгийг бэлтгэн хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэн, дархлаажуулалтын багийн үдийн хоолны зардлыг шийдвэрлэлээ. Эрүүл мэндийн яамнаас 233,5 сая төгрөгийн хувийн хамгаалах хэрэгсэл, 19,9 сая төгрөгийн оношлуур, сүрьеэтэй тэмцэх төслөөс 7,7 сая төгрөгийн хамгаалах хэрэгсэл хүлээн авлаа.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/248 дугаар тушаалаар 28914.6 мянган төгрөгийн санхүүжилт ирж аймгийн Онцгой Комиссын шуурхай штабын жижүүр, Дэлгэр сумын постод ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад илүү цагийн хөлс олгохоор шийдвэрлэн, Эрүүл мэндийн газарт 14537.6 мянган төгрөг, Зооноз өвчин судлалын төвд 6459.0 мянган төгрөг, 3 өрхийн эрүүл мэндийн төвд 3382.0 мянган төгрөг, 7 сумын эрүүл мэндийн төвд 4536.0 мянган төгрөг тус тус хуваарилан нийт 117 албан хаагчид илүү цагийн хөлс олголоо.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг БНХАУ-ын Синофарм үйлдвэрийн VeroCell нэртэй 4170 тун вакцин хүлээн авч бэлтгэл ажлыг ханган, сум бүрт 1 түр цэг аймгийн төвд 5 түр цэг байгуулан вакцинжуулах үйл ажиллагааг зохион байгуулснаар 4071 хүн 1 дүгээр тунд хамрагдлаа.

4 дүгээр сарын 26-ны өдөр 2-р тунгийн 4308 хүн тун вакцин хүлээн авч вакцинжуулах ажлыг эхэлснээр 354 хүн хамрагдаад байна. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинжуулалттай холбоотой Аймгийн Засаг даргын А/134 захирамж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл (ДДУХ)-ийн хариу арга хэмжээний багийг Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар байгуулан ажиллалаа.

Коронавирусийн тархалт, өвчлөлийг бүртгэх Тандалт гэрэгэ систем дээр 22 байгууллагыг бүртгэж 26 хүнд системд нэвтрэх эрх олголоо.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/227 дугаар тушаалаар 14 хоног тусгаарлах байранд тусгаарлан ажиглаж байна.

Нэгдсэн эмнэлэгт-33, Онцгой байдлын газарт-11, “Ентүм” зочид буудалд-22, “Амар–Алтай” зочид буудалд 27, нийт 93 хүн байна.

Жаргалант-14, Баянхайрхан-13, Жинст-6, Харзат-5, Түмэн-9, Индэрт-2, Оргил-5, Наран-11, Рашаант-0, нийт 65 иргэний гэрийн ажиглалтад байгаа бөгөөд Есөнбулаг сумын багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нар хяналт тавьж байна.

2021 оны 04 дүгээр сарын 30–ний өдрийн байдлаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасагт 23 хүн, дотрын тасагт-26 хүн, нийт 49 хүн хэвтэн эмчлүүлж байгаагаас хүндэвтэр-7, хөнгөн-42 иргэн байна. 5 хүн гэрийн болон тусгаарлан ажиглалтад хянагдаж байна.

Сумын эрүүл мэндийн төвүүд, Дэлгэр сумын пост, Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд суурин 4, явуулын 4 цэгээр нийт түргэвчилсэн оношлуураар 1484 PCR, 2920 антиген түргэвчилсэн оношлуураар тус тус шинжилгээ хийлээ.

Зооноз өвчин судлалын төв давхардсан тоогоор 16 байгууллагын 2823 м/квадрат талбайг, 4 автомашиныг ариутгаж халдваргүйтгэсэн.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 10-ны өдрүүдэд худалдаа, үйлчилгээний томоохон 8 объектод гамшгаас хамгаалах болон гал түймрийн хяналтыг зохион байгуулж, 40 зөрчил илэрч, 17 зөрчлийг газар дээр нь арилгуулж, заавал биелүүлэх албан шаардлага 4 хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 1 дүгээр улирлын биелэлтийг гаргаж Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /unelgee.gov.mn/-д байршуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүллээ.

Сар бүрийн 4, 21-ний өдрийн болон долоо хоног бүр дамждаг үнийн, 1 дүгээр улирлын мэдээг хугацаанд нь ҮСХ-нд тус тус дамжууллаа.

Аймгийн нийгэм эдийн засгийн 3 дугаар сарын танилцуулгыг 4 сарын 15ны дотор бэлтгэн гаргаж аймгийн удирдлагууд болон хэрэглэгчдэд хүргэлээ. Мөн нийгэм эдийн засгийн танилцуулгаар инфографик мэдээлэл, презентаци бэлтгэн хэлтсийн вэб сайтанд татан авч танилцах боломжтойгоор байршууллаа.

Төрийн албан хаагчдийн үндэсний бичиг үсгийн мэдлэгийг тодорхойлох судалгааг 4 дүгээр сарын 6-ны өдрөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулж, аймгийн хэмжээнд нийт 4.4 мянган төрийн албан хаагч хамрагдлаа.

Мөн аймгийн хэмжээнд түүвэрлэгдэж ирсэн 82 ААНБ-аас сар бүр короновирусийн нөлөөллийн судалгааг авч ҮСХ-нд дамжуулж байна.

## ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын 1 дүгээр улирлын захирамж /82/, албан даалгаврын /1/ хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэлээ. Захирамжийн биелэлт 72.76, албан даалгаврын биелэлт 61.25 хувьтай байна. Тайлант хугацаанд 64 захирамж гаргаж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Алтай, Жаргалан, Тайшир, Бигэр, Бугат, Дарив, Эрдэнэ, Цээл, Есөнбулаг, Шарга, Халиун сумдын Засаг даргын 213 захирамжийг хянаж, эрх зүйн үндэслэл, албан хэрэг хөтлөлт, стандартын зөрчилтэй захирамж тус бүрт зөвлөмж өглөө.

Аймгийн Засаг даргын болон Засаг даргын Тамгын газрын холбогдох аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан 7 гэрээний төслийг хянаж, тусгах саналыг хүргүүллээ.

Нийтийн албанд томилогдсон 2 албан тушаалтны ХАСХОМ-ыг хуульд заасан /30 хоног/ хугацаанд багтаан гаргууллаа.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс болон Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн 6 албан бичгийн хүрээнд холбогдох баримт материалыг бүрдүүлж, нотлох баримтын шаардлага ханган хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст шалгагдаж байгаа 2 хэрэг дээр хохирогч, иргэний нэхэмжлэгчийг томилуулан хүргүүллээ.

Аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорын “Хэрэг бүртгэлтийн хэрэг хаах тухай” 15 дугаар тогтоолд гомдол гаргах ажиллагаа хийлээ.

Аймгийн хэмжээнд ажлаас хууль бусаар чөлөөлсөн, үндэслэлгүй халагдсан буюу хөдөлмөрлөх эрхтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн маргааны улмаас төрд учирсан хохирлыг барагдуулахаар Прокурорын газраас шүүхэд хандаж нэхэмжлэл гаргах ажлыг зохион байгуулах гэж байгаатай холбогдуулан 13 байгууллагаас нотлох баримтыг бүрдүүлэн аймгийн Прокурорын газарт хүлээлгэн өглөө.

Төрийн албаны зөвлөлд иргэнээс ирүүлсэн гомдлыг шалгахад шаардлагатай баримт, хариу тайлбарыг нотлох баримтын шаардлага ханган хүргүүлж, Цагдаагийн газарт шалгагдаж байгаа 2 хэрэг дээр мэдүүлэг өглөө.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн зөвлөмжийг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, өрсөлдөөнийг хязгаарлахаас сэргийлж, тендерт оролцох сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллагуудын шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж ажиллах чиглэл өгсөн.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсэг, түүний ажиллах журам болон ажлын хэсгийг мэдээллээр хангах журмыг эцэслэн боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барилаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/68 дугаар захиражаар байгуулсан орон нутгийн тусгай сангуудын үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж санал дүгнэлт гаргах ажлын хэсгийн нэгдсэн дүн, холбогдох баримт материалтай танилцаж цаашид зохион байгуулах ажлын чиглэл бүхий зөвлөмжийг Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ.

**Архивын тасаг:** Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 85 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар нийт 1400 хуудас баримт бүхий лавлагаа олгож, Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифын дагуу 1492.0 мянган төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд төвлөрүүллээ. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 6 орон тоог нэмэгдүүлэх тухай хүсэлтийг Сангийн яаманд, 3 орон тооны ажилтны албан тушаалын тодорхойлолтыг хянуулах тухай албан бичгийг Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүллээ.

Байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, баримтанд сэлбэн засалт, сэргээн шинэтгэл хийх талаар сургалт, дадлага хийх хуваарь гарган, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, баримтанд сэлбэн засалт, сэргээн шинэтгэл хийх дадлага, сургалтыг 8 байгууллагын архив, бичиг хэргийн ажилтанд хийж, Алтай, Баян-Уул сумын 16 хадгаламжийн

нэгжид сэлбэн засалт,Тонхил сумын 1992-1995 оны малын А дансны баримт, Халиун, Цогт,Бугат сумын 18 хадгаламжийн нэгжид сэлбэн засалт , сэргээн шинэтгэл хийлгэлээ.

Аймгийн албан байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчилсэн хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж, нийт 27 албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл гаргах журмын дагуу 52 байгууллагын мэдээг тоо бүртгэлийн нэгдсэн систем оруулан баталгаажуулж, Өргөө засал ХХК-ийн гүйцэтгэсэн Солонго хорооллын 30 айлын орон сууц, Алтай сумаас Бургастайн боомт хүртэлх шилэн кабелийн ажлын холбогдох баримт бичгийг архивын сан хөмрөгт хүлээн авч, зөвлөгөө өгч ажиллалаа.

Төв аймаг, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс нотлох баримт гаргуулахаар ирүүлсэн шүүгчийн захирамж, Сонгино хайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн албан бичиг, Говь-Алтай аймгийн сум дундын Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох лавлагаа, хуулбарыг тус тус гаргаж хүргүүллээ. Мөн архивын нийтлэг журмын төсөлд тусгах саналыг нэгтгэж, Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

Бигэр, Жаргалан, Цээл, Тонхил, Дэлгэр сумын 35 хадгаламжийн нэгжийн 26072 хуудас баримтын 24781 хүний нэрийг шивж цахим хэлбэрт шилжүүллээ.

#### ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Эхний 4 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт 2133.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2574.6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 120.7 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 590.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 624.1 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 105.6 хувиар тус тус биелүүллээ.

Сум, байгууллагуудын санхүүжилт, дэмжлэгийг бүрэн олгож, нийт 28806.2 сая төгрөгийн зарлага гаргахаас 19510.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 32.3 хувийн төсвийн хэмнэлт үүсээд байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2020 оны тайланг нэгтгэн <http://e-reporting.eitimongolia.mn/> цахим тайлангийн системээр илгээлээ. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 44 аж ахуйн нэгжээс 303.6 сая төгрөгийн татвар, төлбөр хураамж төвлөрүүлж, 183.7 сая төгрөгийн хандив, дэмжлэг өгсөн байна.

Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн аудит хийлгэн, Сангийн яаманд нэгтгүүллээ.

Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 55 арга хэмжээг тусгаж, 35 арга хэмжээний тендер зарлаад байна.

Тухайлбал: Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 24.0 сая төгрөгийн санхүүжилтээр улсын чанартай автозам дагуу Дэлгэр сумын цаана болон

шинэ хаалга, Ээж хайрхан Уул руу нэвтрэх пост, Баарангийн давааны ам, Тайшир сумын нутагт Завхан голын гүүр гэсэн 5 байршилд хогийн бункер байрлуулах ажлыг “Тэгш Тайшир групп” ХХК-тай гэрээ байгуулан эхлүүллээ.

Улсын төсвийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр Хөхморьт сумын нутагт 25 гад ойн зурвас байгуулах, гүн өрмийн худаг гаргах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгууллаа.

“Газар тариалан жимс, жимсгэнэ” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд сумдын тариалангийн талбай, техник, тоног төхөөрөмж, ажиллах хүч тэдгээрийн зохион байгуулалт, услалтын системийн ашиглалтын өнөөгийн байдал, цаашид хэрхэн сайжруулах талаарх судалгаа болон 2021 оны тариалалт хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, үрийн хэрэгцээг гарган худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үнэлгээ хийж байна.

Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А-3 сертификатын сургалтад 88 иргэн хамрагдлаа.

2021 онд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний мэдээлэл, хэрхэн оролцох боломжийн талаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй барилгын 23 аж ахуй нэгжийн удирдлагуудтай уулзалт зохион байгууллаа.

**Өмчийн асуудлаар:** Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 16 хурлаар хурлаар “Ундарга-Алтай”, “Гэгээн нуур” ААТҮГ-уудын 2021 оны үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөө, цаашид авах арга хэмжээний саналыг хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүллээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 48 дугаар тогтоолын дагуу “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Х County маркийн автобусыг аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулгад хүлээлгэн өглөө.

Нийтийн номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтгүй, илүүдэлтэй хуучин барилгыг Алтай жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжигч хишиг холбоо НҮТББ-ын саналыг судлан түрээслэх зөвшөөрөл олгож барилгыг хүлээлгэж өглөө.

Аймгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2020 оны эд хөрөнгийн бүртгэлийн болон статистик 5 төрлийн тайлан мэдээллийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тус тус хүргүүллээ.

## ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 4 сумын 273 малчин өрхийн 307.8 мянган толгой мал, хилийн зурваст 2 сумын 101 өрхийн 69.0 мянган толгой мал, улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутагт 1 сумын 15 өрхийн 4.6 мянган толгой мал мөн өөр аймгийн нутагт 10 сумын 99 өрхийн 52.0 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 12 сумын 513 өрхийн 253.6 мянган толгой мал отроор хаваржиж байна.

Аймгийн хэмжээнд 18 сумын 88 багийн 7.9 мянган малчин өрхөд 3310.8 мянган толгой мал хаваржиж, төллөвөл зохих 864.6 мянган хээлтэгчээс 483.2 мянган

хээлтэгч мал төллөж 451.0 мянган толгой төл бойжиж, 93.3 хувьтай байна. Том малын 144.7 мянган толгой буюу нийт малын 4.4 хувь нь хорогдоод байна.

Энэ оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар мах 1.7 тн, гурил 290.7 тн, гурилан бүтээгдэхүүн 14.0 тн, будаа 71.7 тн, сүү 12.1 тн, өндөг 6530 ширхэг, ургамлын тос 13.1 тн, төмс 66.5 тн, хүнсний ногоо 28.5 тн, элсэн чихэр 51.1 тн, давс 24.4 тн, цэвэр ус 22.5 тн-н нөөцтэй байна.

Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд өвөлжилт хүндэрсэн сумын малдад туслах тусламжийн 1107 тн хүчит тэжээлийн үлдэгдэл 81760 кг тэжээлийг өвөлжилт, хаваржилт хүндэрсэн Жаргалан, Тайшир, Төгрөг, Цогт, Шарга, Есөнбулаг (6) сумдад хуваарилан малчдад хүргэх ажлыг зохион байгууллаа.

Дэлхийн зөн олон улсын байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслөөс зохион байгуулсан цахим уулзалтад оролцож, зорилтот сум болох Дэлгэр сумын Дагналтайн услалтын системийг түшиглэн тэжээлийн ургамал тариалах ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажил (тухайн тариалангийн газрын товч танилцуулга, төсөл хэрэгжүүлэх газрын эзэмшил өмчлөлийн асуудлыг шийдвэрлэн, ажлын төлөвлөгөөг гаргуулах)-ыг хангууллаа.

Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр 3, Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс ноолуурын дээж авах цахим сургалтыг 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, холбогдох 6 албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

ХХААХҮЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, холбогдох албаныхан хамтран зохион байгуулсан цахим уулзалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнүүд, Хүнс, хөдөө аж ахуйн газрын төлөөлөл болон Жаргалан, Халиун сумдын ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй оролцлоо.

Ургамлын гарал үүсэл, пестицидийн хэрэглээ хяналт-шинжилгээ хөтлөх цахим сургалтад 18 сумын газар тариалан хариуцсан мэргэжилтнүүд оролцлоо.

Бигэр сумд жимс жимсгэнийг боловсруулах бага оврын үйлдвэр, Тайшир сумд Халтар арвайн хүнсний бүтээгдэхүүн, үйлдвэрлэх цех, Гуулин тосгонд ногоон тэжээл тариалах, боловсруулах үйлдвэр, Есөнбулаг сумд Өвлийн хүлэмж байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг хүссэн албан бичгийг Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлаг ТИКА-гийн Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулах газар болон Сангийн яамны хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газарт, мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг ХХААХҮ-ийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт, Аймгийн хэмжээнд мөрдөж байгаа Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн А-117 дугаар тушаалаар шинэчлэн баталсан сум, багийн кодын жагсаалтыг ХХААХҮ-ийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын малын генетик нөөцийн хэлтэст, хаврын тариалалтын бэлтгэл ажилд шаардлагатай бороожуулагч

авах хүсэлтийг ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийн газарт, хүнсний нөөцийн мэдээг 7 хоногт 2 удаа ХХААХҮ-ийн яаманд тус тус хүргүүллээ.

**Мал эмнэлэгийн чиглэлээр:** Засаг даргын А/107 дугаар захирамжийн дагуу малын сэг зэм устгах, халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд 48956 малын сэг зэмийг устгаж, 17185 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийгээд байна.

Мал эмнэлгийн цахим гэрчилгээг мах, арьс ширний гарал үүсэлд олгож байна.

Бигэр, Шарга, Халиун сумд галзуу өвчин оношлогдож холбогдох арга хэмжээг авч, Жаргалан сумд үхрийн боом өвчин гарсантай холбогдуулан хорио цээрийн дэглэм тогтоосон бөгөөд боомын вакцин (5.8 л) хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 төрлийн арга хэмжээнд хамрагдах 1095.0, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх 5 төрлийн арга хэмжээнд хамрагдах 3912.0 мянган малыг малчин өрх тус бүрээр нь Мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөж орууллаа.

Улсын мал эмнэлэгийн ариун цэвэрийн төв лабораториас шүлхий өвчний идэвхтэй тандалтын ажлыг зохион байгуулах, дээж, асуумж судалгаа хэрхэн цуглуулах чиглэлээр 2021 оны 04 сарын 28-ны өдөр зохион байгуулсан цахим сургалтад 30, Дэлхийн байгаль хамгаалах сангаас Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах чиглэлээр зохион байгуулсан цахим сургалтад 10, нийт 40 албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Мөн Мал эмнэлгийн лабораторийн мэргэжилтнүүд Үндэсний итгэмжлэлийн газраас зохион байгуулсан “Хэмжлийн эргэлзээ аргын баталгаажуулалт” сэдэвт сургалтад хамрагдлаа.

## ТАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

**Газрын харилцаа:** Аймгийн Засаг даргын захирамжаар 4 иргэнд орон сууц, үйлчилгээний зориулалтаар газар эзэмших эрхийн гэрээ байгуулан гэрчилгээ олгож, газрын эзэмших эрхийн гэрчилгээ болон барьцааны лавлагааг 14 иргэнд гаргаж үйлчиллээ.

Газрын кадастрын чиглэлээр газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөл, геодези, кадастр, үнэлгээ, хянан баталгааны талаарх цахим сургалтыг зохион байгуулж, 2020 оны үйл ажиллагааны биелэлт, 2021 онд хийж хэрэгжүүлэх ажлууд болон цаашид анхаарах асуудлууд бүхий зөвлөмжийг 18 сумын газрын даамалд гарын авлага зааврын хамт хүргүүллээ.

Мөн сумдын геодезийн цэг, тэмдэгтүүдэд хяналт тавьж, тооллого хийх ажлыг зохион байгуулах үүрэг чиглэл өглөө.

Есөнбулаг сумаас бусад 17 сумын мэдээллийг буюу хот тосгон, бусад суурины газарт инженерийн дэд бүтцийн 2, нийгмийн дэд бүтцийн 5 нийт 7 хүчин зүйлсийн утгыг Газрын үнэлгээний системд оруулж, зам болон бусад инженерийн шугам

сүлжээний мэдээллийг нягтлах, нэгтгэх ажил хийгдэж байна. Тус системд газар эзэмших эрхээ шилжүүлсэн, худалдан борлуулсан, худалдах гэж байгаа 6 газрын үнийн мэдээг газрын биржийн цахим системд бүртгэлээ.

Сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн судалгааг гаргаж Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлээ.

**Барилга, хот байгуулалтын чиглэлээр:** “Арвин бэлт”, “Арвин өргөө констракшн” ХХК-уудын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг Монголын барилгын үндэсний ассоциацид уламжиллаа.

Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Спорт заалын барилгын ажлыг барилгын ажил үргэлжлүүлэх, зөвшөөрлийг сунгалаа.

Алтай хотын үерийн далан байгууламж барих 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлыг хүлээж авах мөн Алтай сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах комиссыг ажиллууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бугат, Шарга, Алтай, Цээл, Төгрөг сумдад баригдаж байгаа барилга байгууламжийн угсралтын ажилд захиалагчийн техник хяналт хийлээ.

“Эрдэнэт” ТӨҮГ-аас нийгмийн хариуцлагын хүрээнд Цогт, Баянтоорой тосгон, Төгрөг, Алтай, Жаргалан сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрыг бага оврын цэвэрлэх байгууламжтай болгох, аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг өртгөтөх ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг тус тус боловсруулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлээ.

**Нийтийн аж ахуйн талаар:** Цэвэрлэх байгууламжийн орчны 50 м<sup>2</sup> талбайн лагийг хлорамин ашиглан ариутгаж, Хөгжил хорооллын 11, 13 дугаар гудамжинд байрлалтай бохир усны шугам бөглөрсний улмаас бохир шингэн хальж, хөрсний бохирдол үүсгэн халдварт өвчин гарах эрсдэлтэй нөхцөл үүссэн нийт 80 м<sup>2</sup> талбайг хлорын идэвх өндөртэй жавелионы 5-10%-ын уусмалаар ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

**Эрчим хүчний чиглэлээр:** Хэрэглэгчдээс цахилгаан эрчим хүчний хангамж, гэмтэл сааталтай холбоотой дуудлагыг хүлээн авч шуурхай ажиллагаагаар барагдуулан, дэд станцуудад үзлэг шалгалтыг тогтмол хийж байна.

Баянтоорой, Тахийн талын нарны цахилгаан станцын батерейн байгууламжийг зөөвөрлөн шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Дулааны эрчим хүчний хангамжийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

**Агаарын тээвэр:** 04 дүгээр сарын 09, 11-ний өдрүүдэд захиалгат нислэг /МИ171 нисдэг тэрэг/ үйлдэгдсэн.

Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах саналыг Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлээ.

**Авто тээвэр:** Тайлант хугацаанд ковид-19 халдварт цар тахлын улмаас хот хоорондын зорчигч тээвэрлэлт болон техникийн хяналтын үзлэг түр зогссон.

Шахмал түлшний үйлдвэр барих ажлын ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд барих газрын байршлыг тогтоож, холбогдох мэдээллийн хамт Эрчим хүчний эдийн

засгийн хүрээлэн ТӨААТҮГ-т [enkhtuvshin@meei.energy.gov.mn](mailto:enkhtuvshin@meei.energy.gov.mn) цахим хаягаар хүргүүллээ.

**Мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Алтай сумаас Бургастай боомт хүртэлх 79.84 км шилэн кабелийн угсралт, суурилуулалтын ажлыг улсын комисс ажиллаж 4 дүгээр сарын 12-нд байнгын ашиглалтад орууллаа.

Тонхил сумд “Юнител” болон “Жи-Мобайл” ХХК-ийн захиалгаар шинэ цамхаг руу антенн шилжүүлэн суурилуулж, сүлжээ орууллаа.

**Авто замын засвар арчлалт:** “ГАА-АЗЗА”ТӨХК авто замын байгууламжийн ашиглалтын байдлын төлөвлөгөөт үзлэг хийх графикийн дагуу Алтай-Баянхонгор, Алтай-Ховд, Алтай-Бургастай, Алтай-Улиастай чиглэлийн авто замд зорчих хэсэгт тогтсон цасан хунгарыг автогрейдрээр хусаж, цэвэрлэх, хальтиргааны эсрэг элс давсны хольцыг цацах ажлыг тухай бүр хийж гүйцэтгэлээ.

### ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Ковид-19-ийн дархлаажуулалтын бэлэн байдлыг хангуулах талаар болон вакцин хийх арга техник, зохион байгуулалтын, халдвараас сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах талаарх зэрэг нийт 3 удаагийн сургалтад 99 албан хаагчийг хамруулан мэдлэг чадварыг нь дээшлүүллээ.

ЭМХТ-өөс зохион байгуулсан “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой гарсан тохиолдлыг бүртгэх мэдээлэх, дүн шинжилгээ хийх” 1 багц цагийн сургалтад 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.

Олон Улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан "Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулья" сэдэвт ОПБХ-ыг онлайнаар зохион байгуулж 6 байгууллагын 90 гаруй судлаач нарын 18 илтгэлийг хэлэлцүүллээ.

Цахим сургалтад хамрагдсан байдал:

д/д	Сургалтын сэдэв	Хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо	Зохион байгуулсан байгууллага
1	“Ковид-19 халдварт цар тахлын өнөөгийн байдал, гэрийн ажиглалтын мэдээлэл, цаашид анхаарах асуудлаар”	105	ЭМГ
2	АШУҮИС-аас зохион байгуулсан “Эрдмийн чуулган-63” сувилагчдын салбар цахим хурал	43	АШУҮИС
3	Өсвөр үеийн 7 хоногийн аяны хүрээнд “Өсвөр үеийнхэнд	32	ЭМГ

	нөхөн үржихүйн тулгамдаж буй асуудлууд”		
4	“Кибер орон зай дахь аюулгүй байдал” цахим сургалт	3	Төрийн албаны зөвлөл
5	"Коронавируст халдварын өнөөгийн нөхцөл байдал, шүлснээс коронавирусийг илрүүлэх оношлогооны зааврын талаар	126	ЭМГ

**Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар:** Аймгийн нэгдсэн эмнэлэгт 04 дүгээр сард 3658 ор хоногийг ашигласнаас хүнд өвчтөн 56 байсан ба нас баралтын 4 тохиолдол гарлаа. Амбулаториар нийт 5274 үйлчлүүлэгч үзүүлснээс томуу, томуу төст өвчинтэй 190 тохиолдол бүртгэгдлээ. Хүүхдийн тасагт 480 ор хоногийг ашигласнаас 10 хүнд хүүхэд эмчлэгдлээ. Энэ хугацаанд нийт 110 эх эсэн мэнд амаржиж 110 хүүхдийг хүлээн авлаа. Нийт 91 мэс засал хийж, түргэн тусламжийн 405 дуудлагад үйлчиллээ. Яаралтай тусламжийн тасагт 512 хүн өөрөө ирж үзүүлснээс 30 буюу 5.8% нь томуу, томуу төст өвчний тохиолдол байлаа. Алсын дуудлагын нийт 13 тохиолдолд үйлчиллээ.

Орон нутгийн Алтай телевизэд 14 удаагийн мэдээ, 2 удаагийн tv шторк, радио, сонин, МОНЦАМЭ агентлагт тус бүр 11 удаагийн цаг үеийн мэдээлэл хийж, иргэдийг мэдээллээр хангалаа.

Миний алтай цахим хуудаст 16 төрлийн мэдээ тавьж 1016 хандалт, алтай мэдээ агентлаг цахим хуудаст 41 төрлийн мэдээлэл тавьж, 2890 хандалт авсан байна.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 6 удаа цахим холболт хийж давхардсан тоогоор 622 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.

Тус аймгийн Эрүүл мэндийн газрын пэйж хуудсаар 79 мэдээлэл, эрүүл мэндийн зөвлөгөө, сурталчилгаа хийгдэж, 13020 хүн хандалт, Эрүүл мэндийн газар Зөвлөгөө пэйж хуудаст 28 ширхэг эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж, мэдээ, мэдээлэл байршуулж, 828 хүн хандалт хийсэн байна. “Бидний-Алтай” цахим хуудаст 6 төрлийн мэдээлэл тавьж 422 хандалт, “Алтай мэдээ агентлаг” цахим хуудаст 8 төрлийн мэдээлэл тавьж, 2250 хандалт авсан байна.

**Боловсрол, соёл, урлагийн чиглэлээр:** Аймгийн БСУГ, НҮБ, БШУЯ-ны СӨБГ-ын боловсруулсан хөтөлбөр, ном, гарын авлагаар НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр цэцэрлэгийн эрхлэгчдэд зориулсан “Цэцэрлэгийн менежмент, манлайлал, технологи и-сургалт” сэдэвт цахим сургалтыг эхлүүллээ.

БСУГ, Лингорс хөтөлбөрийн багтай хамтран англи хэлний багш нарт "Extensive reading" хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх аргын талаар Онлайн сургалт зохион байгуулж англи хэлний 46 багш оролцлоо.

БШУЯ-наас зохион байгуулсан “Сургуульд суурилсан менежмент”, БШУЯ, Гүрэн академи хамтран “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж

байгаа “Менежментийн хичээл” сургалтад, ТАЗ-өөс зохион байгуулсан E-MONGOLIA ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СИСТЕМ”, БҮТ-өөс зохион байгуулсан “ЕБС-ийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”, БШУЯ-аас зохион байгуулсан “Хоцрогдол арилгах хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах” үндэсний хэлэлцүүлэг, Боловсролын чанарын шинэчлэл төслөөс “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5-р шатыг хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт цахим сургалт, хэлэлцүүлэгт холбогдох албан хаагчид оролцож, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

”Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын хувийн хэргийг цахимаар хөтлөх зааврын төсөл”-ийг танилцуулах сургалтад хамрагдаж багш нараас судалгаа авах асуулгыг боловсруулан хүргүүллээ.

Суралцагчдын хоцрогдол, агуулгын түвшинг тодорхойлох зорилгоор БҮТ-өөс зохион байгуулахаар төлөвлөсөн шалгалтын материалыг ашиглан нийт сургуулийн 4, 5, 8, 9, 11, 12 дугаар ангийн сурагчдаас 12 төрлийн судлагдахуунаар явцын үнэлгээг зохион байгууллаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэлд энэ оны төгсөгч 721, өмнөх оны төгсөгч 56, нийт 777 хүүхэд бүртгүүлээд байна. 69 хүнд элсэлтийн ерөнхий шалгалтын талаар зөвлөгөө мэдээлэл өглөө.

2021 оны 04 дүгээр сарын 16, 17, 22-ны өдрүүдэд Биеийн тамирын улсын хорооноос зохион байгуулсан “Биеийн тамирын боловсрол, спортын хөгжил 2021”, “Үндэсний спортын түүхэн өв уламжлал, хөгжлийн хандлага-II” олон улсын эрдэм шинжилгээний хуралд аймгийн биеийн тамирын багш нар оролцлоо.

“Дэлхийн том хичээл-Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хэлэлцүүлгийн талаарх сургалт, мэдээллийг нийт 54 албан хаагчид онлайнаар хүргэлээ.

Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсрол, суурь боловсрол, бүрэн дунд боловсролын түвшний хичээлийн төлөвлөлтийг боловруулж нийт 216 багш, баг хамт олны хичээлийг үнэлж дүгнэн СӨБ-3, Бага-3, суурь-3, ахлах-3 хичээлийг шалгаруулж БМДИ-ийн [esurgalt.itpd.mn](http://esurgalt.itpd.mn) сайтад байршууллаа. Тогтвортой хөгжлийн боловсролын төлөө хамтын санаачилга үндэсний хэлэлцүүлгийн хүрээнд “Дэлхийн том хичээл-Тогтвортой хөгжлийн боловсрол” хичээлийн төлөвлөлтөд СӨБ, бага, суурь, ахлахын нийт 205 хичээл БСУГ-т ирснийг шалгуурын дагуу үнэлж 11 хичээлийг шалгаруулан улсын хэмжээний шалгаруулалтад хүргүүлснээс 8 хичээл улсад шалгарч “Дэлхийн том хичээл”-ийн санд бүртгүүлэх боломжтой болоод байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран судлагдахуун бүрийн “Үнэлгээний шалгуур турших” судалгааны ажил улсын хэмжээнд зохион байгуулагдаж лаборатори 1 дүгээр сургууль, ХЭЦ сургууль хамрагдаж байна.

Химийн олон улсын олимпиадад оролцох багийг шалгаруулах 1 дүгээр шатны онлайн олимпиадыг зохион байгууллаа.

Төсөлт тоглоомын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах аргазүйн сургалтыг МУБИС-ын СӨБС-ын багш, доктор Төртогтохтой хамтран 4 сарын 20-ны өдөр цахимаар зохион байгууллаа. Сургалтад 175 албан хаагч хамрагдаж төсөлт тоглоомын аргазүйн чиглэлээр онол аргазүйн мэдлэгтэй боллоо.

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:** Тайлант сард аймгийн хэмжээнд 18 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан байна. Нийт 7 аж ахуй нэгж байгууллагаас 28 ажлын байрны захиалга ирүүлснийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд хүргэлээ.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон их дээд сургууль төгссөн ажил хайгч 7 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн талаар ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгч гарын авлагаар хангалаа.

Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн салбар зөвлөлийг 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс “Хямралыг урьдчилан харж бэлтгэлтэйгээр даван туулья, ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлэе” уриан дор 1 сарын аян зохион байгуулж, 9 арга хэмжээ төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Нийгмийн халамжийн сангийн талаар:** Цахим эрхийн бичгийн үйлчилгээнд 04-р сард 676 өрхийн 3441 иргэн хамрагдаж 42192.0 мянган төгрөгийн санхүүжилт олголоо.

Тайлант хугацаанд Шарга, Тайшир, Төгрөг, Бугат, Бигэр, Цогт, Баянтоорой, Гуулин, Эрдэнэ, Чандмань сумдад хяналт шалгалт хийж, анхан шатны хувийн хэргийн эмх цэгц, бүрдлийг программтай тулгах, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдэд сургалт зохион байгуулах, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гэрт очиж нөхцөл байдалтай нь танилцаж, заавар зөвлөгөө өглөө.

Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тэтгэвэр 1027 иргэнд 283.3, Ахмад настны хөнгөлөлт тусламж 58 иргэнд 16.7, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 266 иргэнд 79.3, Асаргааны тэтгэмж 1955 иргэнд 191.4, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 63 иргэнд 1.2, Ихэр хүүхдэд олгох тэтгэмж 1 өрхөд 2.0, Жирэмсэн эхийн тэтгэмж 495 иргэнд 18.6, “Цалинтай ээж”-ийн тэтгэмж 2783 иргэнд 136.5, нийт 729.0 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүллээ.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:** Эрсдэлт нөхцөл дэх 2 гэр бүлд нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, зөвлөн тусаллаа.

“Сайн үйлсийн аянд нэгдэцгээе” уриатай frame-ийг иргэдээс гадна төр, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудаар аялуулж өсвөр үе, залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх ажлыг эхлүүллээ. Аяны хүрээнд зорилтот бүлэгт гэр олгох айлын судалгааг хийлээ.

Интернет хэрэглээ эрс нэмэгдэж, өсвөр насны хүүхдүүд цахим орчинд ихэнх цагийг өнгөрүүлж байгаатай холбогдуулан Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, өсвөр насны хүүхдүүдийг цахим орчны эрсдэлээс хамгаалах, зөв зохистой, хариуцлагатай, хяналттай интернет хэрэглээнд төлөвшүүлэхэд олон нийт, эцэг эхчүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудыг анхаарч ажиллахад уриалах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, цахим орчны хор

уршгаас өсвөр насны хүүхдүүдийг хамгаалах, цахим орчинд хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор "Эрүүл аюулгүй цахим орчин" аяныг 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулж байгаа ба аяны хүрээнд нийт 11 ажлыг хийхээр төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллага аж, ахуй нэгжийн дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, гишүүдийг чадавхжуулах чиглэлээр Дэлхийн Зөн ГАОНХХ-тэй хамтран Хөхморьт сумын 5 төрийн байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийн 20 гишүүнийг хамруулан цахим сургалтыг зохион байгуулан, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Хүүхдийн зурсан уран зургаар дамжуулан тэдний танин мэдэхүй, үзэл бодлыг дүрслэх урлагийн төрөл бүрийн аргаар зуруулж, урлаг уран бүтээлийн авьяасыг нь нээж илрүүлэх, чөлөөтэй сэтгэн уран дүрсэлж, зурж сурах зорилгоор "Хүүхдийн ертөнц" гар зургийн уралдааныг 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж, шилдгийг шалгаруулж, шагнаж урамшууллаа.

"Сайн ах, эгч" аяны хүрээнд 5 төрлийн дугуйлан, сургалт зохион байгуулж 42 хүүхдийг хамрууллаа.

Үндэсний өв уламжлал, соёлыг сурталчилан таниулах, гэр бүлийн орчинд цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, зөв дадал хэвшилд уриалах, санаачилга өрнүүлэх, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Гэрээсээ гэрэлтэе" үндэсний цахим аяныг зохион байгуулан, 8 төрлийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэн ажиллаж байна.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 04 дүгээр сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа.

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 8714 иргэнд 3254.1 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан өндөр настан 40, тахир дутуу 10, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 2, нийт 52 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Энэ сард НДЕГ- аас зохион байгуулсан 5 удаагийн цахим сургалтад холбогдох албан хаагчид хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 65 хүнд 112.5 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 47 хүнд 6.3 сая, оршуулгын тэтгэмж 5 хүнд 5.0 сая, ажилгүйдэлийн тэтгэмж 47 хүнд 27.1 сая төгрөгийг тус тус олголоо. Сайн дурын даатгалд нийт 45 хүн хамрагдсанаас 31 хүн ажилгүй, 0-3 насны хүүхдээ асарч буй 14 эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 251 иргэнийг хамруулж 20.1 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 114 хүн орж, үүнээс шинээр-17 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 127 хүний групп сунгагдлаа. Цуцлагдсан 4 хүн байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой лавлагааг 12 хүнд гаргаж өглөө.

## ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгаль орчны чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2021 оны А/155 дугаар захирамжийг хэрэгжүүлэн аймгийн хэмжээнд усны тоо бүртгэлийн ажил зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын А/12 дугаар тушаалаар томилж, 04 дүгээр сарын 26-ны өдөр цахимаар хуралдаж хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллахаар төлөвлөлөө.

Химийн хорт болон аюултай бодисын асуудал хариуцсан салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, зөвлөлийн хурлыг 04 дүгээр сарын 15-ны өдөр хуралдуулж, аймгийн хэмжээнд химийн болон аюултай бодис ашиглаж үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудад явцын хяналт шалгалтыг хийх удирдамжийн төслийг хэлэлцэн, зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах асуудлыг 4 дүгээр сарын 25-ны өдрийн 2 дахь хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

**Аялал жуулчлалын чиглэлээр:** Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайдын санаачилгаар Цагдаагийн ерөнхий газартай хамтран Эрдэнэ сумын Сангийн далай багийн Чойгийн усны зүүн аараг хэмээх газарт хууль бус ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор хяналтын постыг 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 90 хоногийн хугацаатайгаар байгуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газраас ажиллах албан хаагчдын мэдээллийг авч, хуваарь гарган хүргүүллээ.

“Алтайн Хүдэр” ХХК болон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдтэй байгуулах хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан батлууллаа.

**Уул уурхайн чиглэлээр:** Алтайн өвөр говьд хууль бусаар ашигт малтмал олборлож буй үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, дүрсжүүлэн, баримтжуулж зөрчлийг таслан зогсоох зорилгоор Эрдэнэ, Цогт сум болон Баянтоорой тосгонд 04 сарын 06-ны өдрөөс 14-ны өдрүүдэд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, мэргэжилтнүүд, Эрдэнэ сумын Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудтай хамтран хяналт шалгалт хийлээ.

Аймгийн Онцгой комиссын 18 дугаар хурлын шийдвэрээр томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн Есөнбулаг сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын лицензтэй Хан-Алтай ресурс ХХК, Болд-Гянт-Болд ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, КОВИД-19 цар тахлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөгөө өгч, бэлэн байдалд хяналт тавьж ажиллалаа.

“Хан-Алтай ресурс” ХХК-ийн 120 тн багтаамж бүхий тэсрэх материалын агуулахын байнгын байршлыг тогтоолгох хүсэлтийг шийдвэрлэн аймгийн Засаг даргын А/177 захирамжаар батлууллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 14 дүгээр тогтоолыг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүллээ.

## НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтаар: 7 аж ахуй нэгж, байгууллагад улсын байцаагчдын хамтарсан хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 28 заалттай 2 албан шаардлага хүргүүлэн, 19.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, 5,0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа.

Зөвлөн туслах үйлчилгээг 1 байгууллагад хийж, 15 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн биелэлтийг нь хангуулан ажиллаж байна.

Дулааны улирал эхэлсэнтэй холбогдуулан хурдан морины үсэргээ сунгаа удаа дараа зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан аймаг сумдын Засаг дарга, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын холбогдох мэргэжилтэн, морин уяачдын холбоодод албан бичиг хүргүүлж, аймгийн Засаг даргын захирамж гарган, хэрэгжилтийг тооцон ажиллалаа. Тухайлбал: 2 удаагийн морины үсэргээнд 4 насны 160 морь унаж уралдуулсан унаач хүүхдүүдийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийлээ.

*Баталгаажуулалтын чиглэлээр:* 2 аж ахуйн нэгжид гарсан үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэж, үйлдвэрлэлийн ослын 2 актыг хянан баталгаажууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөлтэй хамтарсан төлөвлөгөө боловсруулан, аяны нээлтийг цахим хэлбэрээр зохион байгуулж, цар тахалтай холбогдуулан постонд гарч байгаа албан хаагчдын ажлын байрны ахуйн нөхцөлтэй танилцан, хоолны чанар хүртээмжийг дээшлүүлж, ажлын байрны нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч ажиллалаа. Цаашид цахим сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Цацрагийн хяналтаар: Цацрагтай ажиллагсадын мэргэжлийн шарлагын үеийн хувийн тунд урьдчилан сэргийлэх шалгалтыг 2 аж ахуйн нэгжид хийж, 6 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Цацрагийн дэвсгэр түвшинд хяналт шинжилгээг ус цаг уурын шинжилгээний төвтэй хамтран 1 аж ахуйн нэгжид хийж, дүн мэдээг нэгтгэн гаргалаа.

Харилцаа холбооны хяналтаар: 7 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 36 заалттай 7 зөвлөмж хүргүүлсний гадна 4 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ, 2 аж ахуйн нэгж, 1 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж байгаа бөгөөд 2 байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авч шалган, 1 гомдол мэдээллийг зөрчлийн шинжгүй тул хүлээн авахаас татгалзаж, 1 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүллээ.

Авто замын хяналтаар: Алтай хотыг дайран өнгөрч байгаа улсын чанартай авто замд ашиглагдаж байгаа Тайширын 222,3 м, Лүнгийн 24 м, Естийн амны 18,6 м, Шаргын гаталгын 18,6 м төмөр бетонон гүүрүүдийн ашиглалтын байдалд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, 2 заалт бүхий дүгнэлт хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд 4 байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авч шалган, барилгын ашиглалтын төлөв байдлын тухай 4 дүгнэлт гаргалаа.

Хэмжилзүйн хяналтаар: 1 аж ахуй нэгжид хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 17 заалттай 1 албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

МХЕГ-ын даргын баталсан 01/83 дугаар удирдамжийн хүрээнд 1 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж байна.

Барилгын техникийн хяналтаар: 4 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, барилгын ашиглалтын төлөв байдалд улсын байцаагчийн 4 дүгнэлт гаргаж хүргүүлэв.

Эрчим хүчний хяналтаар: Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 1 аж ахуйн нэгжид хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 31 заалт бүхий 1 албан шаардлага хүргүүлж ажиллав.

Байгаль орчин, газар геодези зураг зүйн хяналтаар: Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 аж ахуйн нэгжид хийж, 5.0 сая төгрөгийн торгууль, 5.4 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор хамтарсан албан шаардлага өгч, 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авч ажиллалаа.

Зөвлөн туслах үйлчилгээг 10 аж ахуйн нэгжид үзүүлж, 35 заалттай 5 зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Геологи уул уурхайн хяналтаар: Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 1 аж ахуйн нэгжид хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 25 заалт бүхий хамтарсан албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч ажиллалаа.

Мөн аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын дагуу уул уурхайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

Мал эмнэлгийн хяналтаар: Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 08/15 дугаар удирдамжийн дагуу Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж буй мал эмнэлгийн үйлчилгээний 4 нэгжид хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 42 заалт бүхий 4 албан шаардлага хүргүүллээ.

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 08/15 дугаар хөтөлбөрийн дагуу Халиун сумын мал эмнэлгийн үйлчилгээний 1 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, бусад нэгжүүдэд хөл хорио цээр тогтоосонтой холбогдуулан тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон байна.

Ургамал хорио цээрийн хяналтаар: МХЕГ-ын 01/06 дугаар удирдамжийн дагуу 1 аж ахуйн нэгжийн тарих үрийн 2 дээж, 4 иргэн, аж ахуйн нэгжийн худалдаалж буй ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний 7 төрлийн 15, нийт 17 дээжийг лабораторийн төлөвлөгөөт шинжилгээнд хамруулж хариуг хүргүүллээ. Мөн МХЕГ, ХААИСургууль, УГТЭШХүрээлэнгээс цахимаар зохион байгуулагдсан 8 удаагийн сургалтад тус тус хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Боловсрол, соёлын хяналтаар: МХЕГ-ын даргын баталсан 1/48 дугаар удирдамжийн хүрээнд Есөнбулаг сумын 5 сургууль, 10 цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа.

Эрүүл ахуй халдвар хамгааллын чиглэлээр: Мэргэжлийн Хяналтын Газрын даргын баталсан 01/45 удирдамжийн дагуу аймгийн төв, Цээл сум, Таяннуурын уурхайд зохион байгуулсан дархлаажуулалтын 9 цэгт эмчилгээ, эрүүл ахуй, эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр хяналт хийн 17 зөрчлийг газар дээр нь

арилгуулан заавар зөвлөгөө өглөө. Хяналт хийсэн дээрх 9 цэгт 2979 хүн хамрагдан, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гараагүй. “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын савласан ундны уснаас дээж авч МХГ-ын Нэгдсэн лабораторид хими ба нян судлалын шинжилгээ хийж байна.

Лабораторид 8 байгууллага, 18 аж ахуйн нэгж, 3 иргэнээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 53 сорьц 215 үзүүлэлт, ундны ус 12 сорьц 90 үзүүлэлт, бохир усны 2 сорьц 14 үзүүлэлтээр хими, нян, хорио цээрийн шинжилгээг хийхэд: Хүнсний бүтээгдэхүүний 5 сорьц 5 үзүүлэлт, ундны усны 4 сорьц 6 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна. Шинжилгээний төлбөр 642.0 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлээ.

#### ЕС. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОНЦЛОГ АЖИЛ:

**Алтай сум:** Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж, Эрүүл мэндийн төвийн 1-р улирлын ажлын тайлан, 2013-2020 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын мэдээллийг хэлэлцлээ.

Хилийн бүсийн 5 сумын Засаг дарга нар ирж Хилийн шеф заставуудтайгаа ажиллах гэрээ байгуулж, хамтран ажиллах санал хүсэлтээ солилцлоо.

Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын Засаг даргын Тамгын газраас уриалан “Даавуун тор” аяныг эхлүүлж, төрийн байгууллагууд, иргэд нэгдэж байна.

Сумын Засаг даргын А/30 дугаар захирамжаар дархлаажуулалтын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Коронавирусийн халдвар бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 04 сарын 24-ний өдрийн А/182 дугаар захирамжийн дагуу сумын эрчим хүч, эрүүл мэндийн төвөөс бусад бүх байгууллагууд хөл хорионы дэглэмийг сахиж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

**Баян-Уул сум:** Коронавирусийн сэжигтэй тохиолдол илэрсэн, тус сумд ойрын хавьтагч ирсэнтэй холбогдуулан сумын онцгой комисс хуралдаж, 04 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн, 5 постонд 140 гаруй төрийн албан хаагчид хуваарийн дагуу 24 цагаар үүрэг гүйцэтгэн, сумын орох, гарах хөдөлгөөнийг хааж, хяналт тавин ажиллаж байна.

Дотуур байрын тасгуудыг 04 сарын 25-ны өдөр чөлөөлж “Тусгаарлан ажиглах байр”-ын зориулалтаар 21 өрөөг засаж, бэлтгэл бэлэн байдлыг хангалаа.

**Бугат сум:** Сумын Онцгой комиссын хуралдаан 2021 оны 04 дүгээр сарын 24-ний орой шуурхай хуралдаж, тус аймгийн Есөнбулаг сумд Ковид-19 гарсантай холбогдуулан сумын төвийн орох гарах хөдөлгөөнийг 04 дүгээр сарын 28-ныг дуустал хугацаанд бүрэн хааж, сумыг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргалаа. Сумын төвийн 4 чиглэлд пост гарган, хяналт тавин ажиллаж байна.

Ковид-19 дархлаажуулалтын 1-р тунг 51 иргэнд хийж, гаж нөлөө илэрсэн хүн байхгүй. Улаанбаатар хот болон бусад газраас ирсэн хүмүүсээс Covid-19 түргэвчилсэн оношлуураар 31 иргэнээс шинжилгээ авсан ба сэжигтэй тохиолдол илрээгүй болно.

**Дарив сум:** Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр нөөцийн хямдарсан 800 боодол өвсийг захиалгын дагуу малчид, мал бүхий иргэдэд хүргэлээ.

Аймагт (COVID-19) цар тахал бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын Захирамжийг үндэслэн сумын Онцгой комисс хуралдан, 2021 оны 04 сарын 26-ны өдрөөс эхлэн тус сумыг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гарч, хяналтын постыг 7 цэгт байгуулан, 57 төрийн албан хаагч, 16 төрийн бус байгууллагын албан хаагчийг ажиллуулж байна.

Цар тахлын эсрэг вакцин 102 хүн/тунг татан авч, иргэдээ вакцинжуулж байна.

Сумын онцгой комиссын шийдвэрээр халдвартай бүс нутгаас ирсэн иргэдийг тусгаарлах 3 гэр барьж, тохижуулан, бэлэн байдлыг хангасан байна.

**Жаргалан сум:** Сумын Онцгой комиссын хурлыг 3 удаа зохин байгуулж, “КОВИД-19” цар тахлын сэжигтэй тохиолдол аймагт бүртгэгдэж батлагдсан тул сумын хэмжээнд 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдрийг дуусталх хугацаанд 0 зогсолт хийж, 3 чиглэлд эргүүл пост ажиллуулахаар шийдвэрлэв.

Мөн хүнсний дэлгүүрүүдийн үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 04 дүгээр сарын 27-ны өдрийн хүртэл үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарлаж, 04 сарын 27-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл иргэдэд хүргэлтээр үйлчилгээ үзүүлэх шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

“КОВИД-19”-ын БНХАУ-ын Синофарм үйлдвэрт үйлдвэрлэсэн Вероцелл вакциныг 41 иргэнд хийсэн. 7 хүнийг тусгаарлан ажиглах байранд тусгаарлаж, 15 хүнээс “КОВИД-19”-ын шинжилгээ түргэвчилсэн оношлуураар авахад бүгд сөрөг гарсан.

**Тайшир сум:** Covid 19 сэжигтэй тохиолдлын сорьцыг тээвэрлэн аймагт хүргэж, аймгийн шуурхай штабаас өгсөн үүргийн дагуу шуурхай арга хэмжээ авах баг гүүрний постонд Завхан аймгаас Алтай сумын цэргийн анги руу явж байгаа 11 хүнээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч [www.burtgel.mohs.mn](http://www.burtgel.mohs.mn) хаягаар шивж оруулсан.

Ковидын вакцинжуулалтын төлөвлөгөө боловсруулж, Соёлын төвд вакцин хийх байнгын цэгийг байгууллаа.

Вакцины 33 хүн тунг эхний ээлжинд ЭМТ-ийн ажилчид, цагдаа, эрчим, онцгой комиссын гишүүдийг дархлаажуулалтад хамрууллаа.

**Тонхил сум:** Сумын онцгой комиссын шийдвэрийн дагуу Ховд аймагт Корона вирус батлагдсан тохиолдол илэрсэнтэй холбогдуулан Ховд аймагтай хил залгаа 4-н сумыг аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу 3 цэгт хяналтын постын гэрийг барьж тохижуулав.

Сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 31 –ны өдрийн А/21 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын үед авах арга

хэмжээ”–ний хүрээнд хяналт постонд нийт 100 албан хаагч 24 цагийн хугацаанд үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Аймгийн онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн Алтансоёмбо багт нэмэлтээр 2 постонд 16 төрийн албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Ковидын халдвараас сэргийлэх, дархлаажуулалтыг дэмжих зорилгоор нийт 128 иргэнийг вакцинд хамрууллаа.

**Төгрөг сум:** Сумын засаг даргын А/33 дугаар захирамжаар ковидын халдвараас сэргийлэх, дархлаажуулалтыг дэмжих зорилгоор 50 иргэнийг хамрууллаа.

Сумын Засаг даргын захирамжаар 04 дүгээр сарын 24-ний өдрийн 18 цагаас 04 дүгээр сарын 27-ны өдрийн 21:00 цаг хүртэл хөдөлгөөнийг бүрэн зогсоож коронавирусын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бүх шатны зохион байгуулалтын арга хэмжээг авах шуурхай штабын хариуцлагатай жижүүрийг гарган ажиллаж, сумын хэмжээнд 0 зогсолт хийж ус түгээх байр, ШТС –ын үйл ажиллагааг бөөгнөрөл үүсгэлгүй, хэвийн үйл ажиллагааг тасалдуулахгүйгээр ажиллуулж байна.

Сумын засаг даргын 2021оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/42 дугаар захирамжаар 04 дүгээр сарын 28-ны өдрийн 18:00 цагаас 05 дугаар сарын 02-ны өдрийг дуустал 0 зогсолтыг сунгах шийдвэрийг гаргалаа. Сумын орох, гарах хөдөлгөөнийг зогсоож, эргүүл постыг 4 чиглэлд, 24 цагаар ажиллуулж байна.

Сумын эрүүл мэндийн төв нь Коронавирусийн халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн амбулаторийн тусламж үйлчилгээг гэрийн нөхцөлд шилжүүлэн иргэдийг гэрээр очиж үзэн, эмийн сангийн үйлчилгээний хүргэлт хийх үйлчилгээг үзүүлж байна. Гэрээр эрүүл мэндийн амбулаторийн тусламж үйлчилгээг 18 хүнд үзүүлж, 40 хүнд эмийн сангийн үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.

Түргэвчилсэн оношлуураар 26 хүнийг шинжилгээнд хамруулахад 1 иргэний шинжилгээ эерэг гарч, шинжилгээний хариуг аймаг руу явуулж хариуг иртэл тус иргэнийг тусгаарлан эмчилгээ хийж байна. Мөн хамт ирсэн 2 иргэний давтан шинжилгээний хариу иртэл тусгаарлан холбогдох арга хэмжээг авсан байна.

**Цээл сум:** Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулан сумын Онцгой комиссын 10 гишүүн, ЭМТөвийн 27, ШТСанцын 2, Эрчим хүчний 2 ажилтан, Алтайн Хүдэр ХХК-ийн 400 ажилтан, нийт 441 иргэн вакцинжуулалтад хамрагдсан байна.

УБ хотоос 5 тээврийн жолооч ирсэнийг хяналтад авч, шинжилгээнд хамруулан 4 жолоочийг тусгаарлаж, 1 жолооч нь 24 цагтаа буцсан.

**Шарга сум:** Тус сумын 38 иргэн вакцинжуулалтад хамрагдлаа.

Сумын онцгой комисс 2 удаа хуралдаж Засаг даргын 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/65, 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/66 захирамжуудаар 4 чиглэлд пост гарган ажиллуулж байна. Захирамжаар сум доторх болон орох гарах бүх хөдөлгөөнийг хязгаарлаж иргэдийн хөдөлгөөнд хөдөлгөөнт эргүүл, сумаас гарах орох хөдөлгөөнд постууд хяналт тавин ажиллаж байна. Мөн хүнсний дэлгүүр, эмийн сангийн үйлчилгээг хүргэлтээр үзүүлж байна. Төрийн албан хаагчид гэрээсээ цахимаар, сумын онцгой комиссын гишүүд шуурхай штабт жижүүрээр ажиллаж байна.

Ховд аймагт ковид-19 халдвар бүртгэгдсэнтэй холбоотой сумын Онцгой комиссын хурлын шийдвэр, сумын Засаг даргын А/38 дугаар захирамжийн дагуу Далан Ээвд хяналтын постыг ажиллуулж байна. Мөн Далан Ээв, заг овооны гүүрний айл өрхийн гуанз, худалдаа үйлчилгээг түр хугацаагаар хориглосон болно.

**Эрдэнэ сум:** Тус сумд коронавирусийн 1 тохиолдол батлагдсан тул бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин 6 чиглэлийн постонд 72 албан хаагч ажиллаж байна.

Соёлын төвд вакцинжуулалтын байр засаж, 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, 40 иргэнийг вакцинжуулалтад хамрууллаа. Сургуулийн дотуур байрыг тусгаарлах байрны зориулалтаар тохижуулсан.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

